



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2026.03.27 № 17

“Мэдээллийн технологийн  
үйлдвэрлэлийг дэмжих тухай” хуулийн  
хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдөр Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг баталсан. Уг хуулиар мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг төрөөс дэмжих эрх зүйн үндсийг тогтоож, нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн олговор олгох, дэвшилтэт технологийн судалгаа, хөгжүүлэлтэд грант олгох, шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлохын зэрэгцээ төр нь цахим систем, программ хангамжийн шинэ бүтээгдэхүүнийг өөрөө хөгжүүлэхээс татгалзаж, худалдан авах ажиллагаагаар хэрэгжүүлэх зарчмыг хуульчилсан. Тус хууль батлагдсанаар Монгол Улсын мэдээллийн технологийн салбарын өсөлт эрчимжиж, дотоодын болон олон улсын зах зээлд өрсөлдөхүйц түвшинд хүрнэ гэсэн хүлээлт салбарт үүссэн. Гэвч хуульд заасан дэмжлэг өнөөдрийг хүртэл бодитоор хэрэгжээгүй байна.

Уг хуулийн хэрэгжилтийн нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг тодруулах зорилгоор Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал миний бие 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Төрийн ордонд “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Хэлэлцүүлэгт оролцсон Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар, Ж.Галбадрах нарын хамтаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны, Сангийн, Эдийн засаг, хөгжилийн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны болон Мэдээллийн технологийн үндэсний парк, тухайн салбарын аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзаж мэдээлэл сонссон.

Хэлэлцүүлгээс дүгнэхэд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас хуулийг хэрэгжүүлэх талаар тавьсан асуудалд бусад яамд, Засгийн газрын тусгай сангууд тодорхой хариу өгөөгүй, нэгдсэн байр сууринд хүрээгүй, бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэх шалтгаанаар хойшлуулж ирсэн байна. Таныг Засгийн газрын тэргүүний хувиар манлайлал үзүүлж, танхимын зарчмаар нэгдсэн байр сууринд хүрч ажиллавал хууль хэрэгжих боломжтой гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

1.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-т “мэдээллийн технологийн үйлдвэрлэлээс төсөвт төвлөрүүлсэн мөнгөн

3026000049

хөрөнгийн 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө” гэж заасан виртуал бүсэд бүртгүүлсэн хуулийн этгээдэд үзүүлэх дэмжлэгийн эх үүсвэрийг 2024-2026 онд бүрдүүлээгүй шалтгаан, нөхцлийн талаар;

2.Мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-т “виртуал бүсэд бүртгэгдсэн мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд нөхөн олговор олгох;” гэж заасан виртуал бүсэд бүртгэлтэй этгээдийн нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн олговрыг олгох ажиллагаа хэрэгжихгүй байгаа шалтгаан, нөхөн олгож эхлэх хугацаа;

3.Мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4-т “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.5, 5.3.18, 5.3.20-д заасан Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн 5-аас доошгүй хувь” гэж заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийн, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Шинжлэх ухаан, технологийн сангуудын хөрөнгийн 5-аас доошгүй хувийг мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжихэд зарцуулахгүй байгаа шалтгаан;

4.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “төр мэдээллийн технологийн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс татгалзаж худалдан авах ажиллагаагаар хэрэгжүүлэх” гэж заасан бодит байдалд хэрэгжихгүй байгаа шалтгаан, Засгийн газар ямар арга хэмжээ авах талаар;


5.Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 02 дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл өгч, улсын нэгдсэн төсвийн ангилалд мэдээллийн технологийн арга хэмжээ болон кибер аюулгүй байдлын зардлын ангиллыг шинээр бий болгож, тэдгээрийг программ хангамж, техник хангамжийн зардлаар ялган бүртгэх нөхцөлийг бүрдүүлэхийг даалгасан байхад өнөөдрийг хүртэл баталж, хэрэгжүүлэхгүй байгаа шалтгаан;

6.Хуулийн үйлчлэх хүрээг зөвхөн программ хангамж хөгжүүлэлтээр хязгаарласныг “техник хангамж, мэдээллийн технологийн үйлчилгээ, их өгөгдөл, аналитик, хиймэл оюун ухаан, кибер аюулгүй байдал, аудит нийцэл” зэргээр салбарыг бүхэлд нь хамруулах талаар Засгийн газраас баримталж байгаа бодлого;

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд илүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

  
Ж.ЗОЛЖАРГАЛ

  
Ч.АНАР

  
Ц.МӨНХБАТ

  
Л.СОРОНЗОНБОЛД

  
Ж.ГАЛБАДРАХ

2026000049